

БАТЛАВ.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

П. АЛТАН-ОД

ATA12939 6806252 9024070591

БАТЛАВ.

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭРДЭНЭБАЯР

### “ОЮУТНЫ ХАКАТОН” ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2025 оны 13 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлэгт “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд бүсүүдэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, санал, шийдэл боловсруулахад оюутан залуусын бүтээлч сэтгэлгээ, оролцоог хангаж, хөгжилд нөлөөлөхүйц төслүүдийг шалгаруулах зорилгоор “Оюутны хакатон” тэмцээнийг улсын хэмжээнд зохион байгуулна.

Тус тэмцээний зорилго нь оюутнууд богино хугацаанд асуудал шийдвэрлэх чадвар, багийн ажиллагаа, бүтээлч сэтгэлгээгээ ашиглан “Оюутны Хакатон” тэмцээнээр дамжуулан бүс, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэх технологи, шинэ санаа, бүтээлээр дамжуулан олон талын оролцоог хангасан шийдэл гаргахад оршино.

#### Хоёр. Тэмцээний сэдэв

“Оюутны Хакатон” тэмцээнээр дамжуулан бүс, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэх төслийг шалгаруулахад дараах ерөнхий чиглэлийг баримтална.

| №  | Ерөнхий чиглэл                         | Шийдвэрлэх асуудал                                                                                                                                                            |
|----|----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Тогтвортой хөгжил ба нөөцийн удирдлага | Байгалийн нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалт<br>Ногоон эрчим хүч, сэргээгдэх эх үүсвэрийн нэвтрүүлэлт<br>Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх стратеги |
| 2. | Дэд бүтэц ба ухаалаг хотын шийдлүүд    | Зам тээвэр, логистик, нийтийн тээврийн ухаалаг систем<br>Хог хаягдлын менежмент, дахин боловсруулах инновац<br>Усан хангамж, бохир усны зохистой удирдлага                    |
| 3. |                                        | Бүс нутгийн гарааны бизнес, жижиг дунд үйлдвэрийг дэмжих                                                                                                                      |

|                                                   |                                                                                                                                                                            |
|---------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эдийн засгийн өсөлт ба ажлын байрны хөгжил        | Хөдөлмөрийн зах зээлийн шинэ боломжууд, алсын зайны ажил<br>Бүс нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлэх                                                   |
| 4. Хөдөө аж ахуй, хүнсний тогтвортой байдал       | Ухаалаг газар тариалан, дэвшилтэт хөдөө аж ахуйн систем<br>Мал аж ахуйн шинэ технологи, биотехнологийн хэрэглээ<br>Хүнсний хангамж, хадгалалт, хаягдлыг бууруулах шийдэл   |
| 5. Нийгмийн хөгжил ба хүртээмжтэй үйлчилгээ       | Эрүүл мэндийн салбар дах асуудлыг шийдэх дижитал шийдэл<br>Боловсролын тэгш боломж, дижитал боловсролын платформ<br>Ухаалаг хот ба бүс нутаг                               |
| 6. Аюулгүй байдал ба гамшгийн эрсдэлийн удирдлага | Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх систем<br>Кибер аюулгүй байдал, дата хамгаалалт<br>Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх инновац                |
| 7. Хүртээмжтэй инновац ба технологийн хөгжил      | Бүс нутгийн дижитал шилжилт, дата платформууд<br>Хиймэл оюун ухаан, IoT, Big Data-д суурилсан шийдлүүд<br>Төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагааны технологи        |
| 8. Соёл, аялал жуулчлалын хөгжүүлэлт              | Бүс нутгийн соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх<br>Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ухаалаг шийдэл<br>Соёл, бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх платформ |

### Гурав. Хамрах хүрээ

Мэргэжлийн боловсролын их сургууль, политехник коллеж, коллеж, дээд сургууль, их сургуулийн I-VI түвшний оюутан.

- Баг тус бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- Багт нэг чиглүүлэх зөвлөх байж болно.
- Баг бүрдүүлэх боломжгүй оролцогч ганцаараа бүртгүүлэх боломжтой. (Оролцох тохиолдолд бүртгэлийн тусгай хуудсыг бөглөнө үү)

### Дөрөв. Зохион байгуулагч

- Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам;
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим;
- Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ.

### Тав. Шалгаруулах журам

**Нэгдүгээр шат- 2025.04.01- 2025.04.23**

- Нийт оролцогчид 4 дүгээр сарын 01-ээс 4 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл <https://regional.gov.mn/event> хаягаар бүртгүүлнэ.

- Ганцаарчлан бүртгэл хийлгэсэн оролцогчид 4 дүгээр сарын 12-ны өдөр шинэ баг бүрдүүлнэ. Тухайн өдөр нийт оролцогч багууд дараах 6 сэдвээр чиглүүлэх сургалтад хамрагдаж төслийг сайжруулна. Үүнд:
 

|    |                                               |          |
|----|-----------------------------------------------|----------|
| 1. | Хакатон арга хэмжээний чиглүүлэх сургалт      | 20 минут |
| 2. | Бүсчилсэн хөгжлийн бодлогын сургалт           | 20 минут |
| 3. | Инновацын сургалт                             | 20 минут |
| 4. | Загварчлах сэтгэлгээ/Design Thinking/ сургалт | 20 минут |
| 5. | Бизнес модель төслийн сургалт                 | 20 минут |
| 6. | Менторшип                                     | 20 минут |
- Нийт оролцогч багууд төслөө 70-100 хувийн гүйцэтгэлтэй сайжруулан, 3 минутын танилцуулга бичлэгийн хамт 4 дүгээр сарын 17-ны өдрийн 12:00 цаг хүртэл <https://regional.gov.mn/event> бүртгэлийн системээр ирүүлнэ.
- Оролцогчдоос ирүүлсэн видео танилцуулгыг 2025.04.21-2025.04.24-ны хооронд “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн”-ийн цахим хаягт байршуулж, олон нийтээс санал авч хиймэл оюун ухаан ашиглан тооцоолуулна.
- Шүүгчид болон олон нийтийн саналын үнэлгээгээр шалгарсан багууд хоёрдугаар шатанд оролцоно.

#### **Хоёрдугаар шат- 2025.04.26**

- Хоёрдугаар шатанд шалгарсан багууд төслөө оролцогчид болон шүүгчдийн бүрэлдэхүүнд 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр танилцуулна. Төслийн танилцуулгад үндэслэн шүүгчдийн бүрэлдэхүүн аваргыг дараах оноонд үндэслэн шалгаруулна. Үүнд:

#### **Нэгдүгээр шатны үнэлгээний шалгуур үзүүлэлт:**

1. Шийдлийн инновац, шинэлэг байдал
2. Техникийн хэрэгжилт, хөгжүүлэлтийн чанар
3. Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө
4. Практик хэрэгжих боломж, тогтвортой байдал
5. Олон нийтийн санал

#### **Хоёрдугаар шатны үнэлгээний шалгуур үзүүлэлт:**

1. Шийдлийн инновац, шинэлэг байдал
2. Техникийн хэрэгжилт, хөгжүүлэлтийн чанар
3. Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө
4. Танилцуулга, илтгэлийн чанар

5. Практик хэрэгжих боломж, тогтвортой байдал
6. Багийн ажил, хамтын ажиллагаа

### Шагнал, урамшуулал

|    |              |   |                     |               |
|----|--------------|---|---------------------|---------------|
| 1. | Тэргүүн байр | 1 | Цом, дурсгалын зүйл | Мөнгөн шагнал |
| 2. | Дэд байр     | 1 | Цом, дурсгалын зүйл | Мөнгөн шагнал |
| 3. | Гутгаар байр | 1 | Цом, дурсгалын зүйл | Мөнгөн шагнал |
| 4. | Тусгай байр  | 2 | Дурсгалын зүйл      | Мөнгөн шагнал |

### Тусгай шагналууд:

|                                                                                                                                                                                                                                                      |                                  |   |               |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------|---|---------------|
| 1.                                                                                                                                                                                                                                                   | Шилдэг технологийн шийдэл        | 1 | Мөнгөн шагнал |
| 2.                                                                                                                                                                                                                                                   | Шилдэг нийгэмд нөлөөлөлтэй төсөл | 1 | Мөнгөн шагнал |
| 3.                                                                                                                                                                                                                                                   | Хамгийн шинэлэг санаа            | 1 | Мөнгөн шагнал |
| 4.                                                                                                                                                                                                                                                   | Шилдэг танилцуулга (pitching)    | 1 | Мөнгөн шагнал |
| <ul style="list-style-type: none"> <li>• МҮХАҮТ-ын зүгээс хэрэгжих боломжит төлүүдийг бүсүүдийн инкубатор төвд бойжуулна.</li> <li>• Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын хамтран ажилладаг байгууллагад дадлагажих эрх олгоно.</li> </ul> |                                  |   |               |

### Зургаа. Төсөлд тавигдах шаардлага

- Оролцогч багууд асуудлыг тодорхойлохдоо бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэх;
- Тэмцээнд ирүүлж буй шийдэл нь тухайн бүс нутгийн онцлогт тохирсон, бодит хэрэглээтэй байх;
- Шийдэл нь уламжлалт аргаас ялгаатай, илүү дэвшилтэт, технологид суурилсан байх;
- Бага зардлаар үр өгөөж гаргах, тогтвортой хөгжлийг дэмжих технологиуд ашигласан байх;
- Шийдэл нь тухайн бүс нутгийн иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт авчрах боломжтой байх;
- Бүсийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх шинэ прототипүүд (prototype) гаргасан байх.

### Долоо. Шүүгчдийн бүрэлдэхүүн

- Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн төлөөлөл;
- Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн төлөөлөл;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төлөөлөл;
- Шинжлэх Ухааны Академийн төлөөлөл;
- Их, дээд сургуулиудын төлөөлөл;
- Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын төлөөлөл;

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимийн төлөөлөл;

#### **Найм. Хүлээгдэх үр ДҮН**

- Оролцогчид бүс нутгийн асуудлыг илүү гүнзгий ойлгож, шинэ санаачилга гаргана.
- Оюутан залуусын оролцоотойгоор бүсийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх шинэ санаачилга, бизнес санаа, технологийн шийдлүүдийг бий болгож хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- Дижитал технологид суурилсан шийдлүүдийн прототипийг боловсруулна.
- Хакатоноос гарсан санаануудыг цааш хөгжүүлэх инкубатор, стартап хурдасгуур хөтөлбөрүүдэд оруулах боломж бүрдэнэ.

#### **Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу.**

- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам: <https://mddic.gov.mn/mn/>
- Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн: [www.regional.gov.mn](http://www.regional.gov.mn)

#### **Холбоо барих:**

**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

Утас: 51-262798

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ,**

Утас: 51-265115 |

## ТАНИЛЦУУЛГЫН АГУУЛГА

| №  | Агуулга                            | Тайлбар                                                                                    |
|----|------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|
| 1  | Төслийн танилцуулга                | Багийн гишүүдээ танилцуулж, оролцох болсон шалтгаанаа оруулах боломжтой.                   |
| 2  | Төслийн шийдвэрлэх гэж буй асуудал | Бүтээгдэхүүнээр дамжуулан шийдвэрлэх 1-ээс 3 асуудлыг тодорхойлох боломжтой.               |
| 3  | Төслийн шийдэл                     | Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулахуйц товч бөгөөд тодорхой шийдлийг танилцуулах боломжтой. |
| 4  | Төслийн зах зээлийн хэмжээ, боломж | Зах зээлийн хэмжээ, боломжийг хэмжиж болохуйц тоогоор тодорхойлох боломжтой                |
| 5  | Төслийн бүтээгдэхүүн               | Бизнесийнхээ борлуулж буй бодит бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх боломжтой.                |
| 6  | Төслийн хамрах хүрээ, үе шат       | Бизнесийнхээ өсөлт, гол зорилго, дараагийн алхмуудыг оруулах боломжтой.                    |
| 7  | Төслийн баг                        | Багийнхаа үндсэн гишүүдийг танилцуулна.                                                    |
| 8  | Төслийн багийн өрсөлдөх чадвар     | Өрсөлдөх зах зээлээ тодорхойлж, өөрийн онцлогийг оруулах боломжтой.                        |
| 9  | Төслийн төсвийн задаргаа           | Зорилгодоо хүрэх санхүүгийн тооцоолол, задаргааг оруулах боломжтой.                        |
| 10 | Төслийн хөрөнгө оруулалт, задаргаа | Хөрөнгө оруулагчдаас юу хүсэж байгаагаа оруулах боломжтой.                                 |

## БИЧЛЭГ ТАНИЛЦУУЛГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1920×1080 нягтаршил бүхий дэлгэцийн форматтай, дуу дүрсний өндөр чанартай видео бичлэг байна.

Үндсэн шаардлагууд:

- Төслийн санаачлагч өөрөө танилцуулга хийсэн байх;
- Танилцуулгыг Power Point хэлбэрээр бэлтгэсэн байх;
- 3 минутад багтаан өөрийн бүтээл болон санааг оновчтой илэрхийлсэн байх;
- Зориулалтын микрофонтой байх;
- Гэрлийн тусгал сайтай байх.

---oOo---